



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/20.

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Гэр бүлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.3, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Гэр бүлийн хөгжлийн өдөртэй болох тухай” 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээнд 2018 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан тус арга хэмжээний нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Чингис хотноо зохион байгуулж 3000000 /гурван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Дээрх нээлтийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
3. Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны
..... дугаар сарын..... өдрийн
дугаар захирамжийн хавсралт



**ГЭР БҮЛИЙН ӨДРИЙН НЭЭЛТИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	LED дэлгэц	цаг	4	600000	2400000
2.	Баннар	метр	5м*4ширхэг	8000	100000
3.	Тайз засал /хана хийх, өнгийн даавуунууд, хажуугийн баннар/				500000
	Нийт				3,000,000